

## ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ 2014 ОНЫ АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ

### АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Авилгын эсрэг үйл ажиллагааны төлөвлгөөг оны эхэнд тавьж буй зорилтууд, хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл, хугацаа, хариуцах ажилтанг тодорхой байдлаар төлөвлөн боловсруулж Авлигтай тэмцэх газрын саналыг тусгаж Үндэсний Статистикийн Хорооны даргаар батлуулан хэрэгжүүлэх арга хэмжээг авч ажиллаа.

Үйл ажиллагааны нэг томоохон хэсэг болох Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, энэ талаархи мэдээллийг иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцөлийг хангах, Авлигын эсрэг хууль тогтоомжийг боломжит хэлбэрээр сурталчлах ажлын хүрээнд Сурталчилгааны теле шторк, богино хэмжээний мэдээллийг албан хаагчид, иргэдэд мэдээллийн самбар, цахим хуудасаар дамжуулан таниулга сурталчилгааны бэлэн шторкыг өөрийн биеэр Авлигтай тэмцэх газрын ажилтан Цолмонгоос очиж авч уг шторкыг байнга явуулж байгаагаас гадна Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн сурталчилгааны хэвлэмэл материалыг мөн авч өөрийн хэвлэх цехид хувилуулан Орон нутгийн 21 статистикийн хэлтэст хүргүүлсэн.

Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг ба нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг цахим хуудсанд байршуулах олон нийтэд танилцуулах, сонирхогч бүлгүүдтэй харилцан санал солилцох боломжийг бүрдүүлсэн бөгөөд тайлант хугацаанд шинээр боловсруулсан бодлогын баримт бичиг болон нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргаагүй байна.

Төсвийн орлого, түүний зарцуулалт, гадаадын зээл, тусламж, түүний хуваарилалтыг олон нийтэд тухай бүр байгууллагын цахим хуудасаар мэдээлж хэвшсэн бөгөөд тайлант хугацаанд гадаадын зээл, тусламжаар шинээр хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр, байхгүй байлаа.

Хүний нөөцийн болон байгууллагын стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журмыг цахим хуудсандаа энгийн ойлгомжтой байдлаар байршуулсан бөгөөд Хүний нөөцийн ил тод байдлыг хангах, олон нийтийг түүнтэй танилцах боломжоор хангах байдлыг нээлттэй ил тод болгох ажлын хүрээнд сул орон тооны зарыг байгууллагын болон Төрийн албаны цахим хуудаст тухай бүр байршуулж, байгаагаас гадна байгууллагын цахим хуудсаар хүний нөөцөд бүртгүүлэх цонхыг иргэдэд ойлгомжтой байдлаар нээсэн бөгөөд бүртгүүлсэн иргэдийн мэдээлэлтэй байгууллагын удирдлагууд танилцах бүрэн боломжтой болгосон.

Ажлын сул байр болон сонгон шалгаруулалтыг холбогдох хууль журмын дагуу Төрийн албаны зөвлөлд мэдэгдэн улмаар олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлах зохион байгуулалтын арга хэмжээг тухай бүр хэрэгжүүлнэ.

Албан хаагчдын ажлын гүйцэтгэл, үр дүнг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох чиглэлээр Төрийн албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн мэргэжлийн түвшинг үнэлэх журмыг мөрдлөг болгон ажиллаж байна.

Тендер шалгаруулалт явуулах журмыг цахим хуудас болон цахим мэдээллийн самбарт албан ёсоор байршуулсан болно.

Тайлант хугацаанд тендер, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагаа хийгдээгүй байна.

Тайлант хугацаанд гадны байгууллагтай хамтран ажиллах ажлын хүрээнд судалгаа, зөвлөх үйлчилгээний Эм Эм Си Жи (MMCG) байгууллагаар статистик тоо мэдээллийг тогтмол хэрэглэдэг Үндэсний статистикийн хорооны Мэдээлэл, сургалт, судалгааны төв (МССТ)-д бүртгэлтэй хэрэглэгчид болон тус төвөөр ирж үйлчлүүлсэн хэрэглэгчдийн дунд тодорхой асуулгаар судалгаа хийж, статистикийн бүтээгдэхүүн, үйлчилгээний сэтгэл ханамжийн түвшинг тодорхойлж тайланг нэгтгэн гаргасан болно.

Уг судалгаанд Үндэсний Статистикийн Хорооны Мэдээлэл, сургалт, судалгааны төв /МССТ/-д бүртгэлтэй, 7 салбарыг төлөөлсөн 370 статистикийн тоо мэдээллийг тогтмол хэрэглэгчид болон тус төвөөр ирж үйлчлүүлсэн 30 тогтмол бус хэрэглэгч оролцсон байна.

Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ёс зүйн дүрмийг тогтоон мөрдүүлэх ажлын хүрээнд:

- Ёс зүйн хорооны зарим гишүүд өөр ажилд шилжсэнтэй холбоотойгоор Төрийн албаны зөвлөлийн Үндэсний Статистикийн хорооны дэргэдэх салбар зөвлөлийн 2014 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 2 дугаар тогтоолоор Ёс зүйн хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулсан.
- Үндэсний Статистикийн Хорооноос Мэргэжлийн ёс зүйн дүрмийг Монгол Улсын "Статистикийн тухай" хуулийн 7 дугаар зүйлийн 1-д дэх заалт, 12 дугаар зүйлийн 3 дах хэсгийн 3 дугаар заалт, 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дүгээр заалт, ҮСХ-ны Даргын зөвлөлийн 2013 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн хуралдааны шийдүүдийг үндэслэн баталж, 2013 оны 04 дүгээр сарын 15-наас эхлэн мөрдүүлж эхэлсэн.
- Дээрх дүрмийг Үндэсний Статистикийн Хорооны ажилтнуудад байгууллагын вэб сайт /www.nso.mn/ -д байршуулан нээлттэй хэлбэрээр хүргэсэн. Мөн Үндэсний Статистикийн Хороонд шинээр ажилд орсон 14 ажилтанд 2014 оны 11 дүгээр сарын 6-ний өдөр дүрмийг танилцуулан мэдээлэл хийсэн.

Зөрчлийн талаарх мэдээлэл хүлээн авах нөхцөл ажлын хүрээнд Төрийн албаны зөвлөлд "Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг ханган, ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх журам"-ын дагуу төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн зөрчлийн мэдээг хагас болон бүтэн жилээр гарган хүргүүлж байна.

Ёс зүйн хорооноос байгууллагын ёс зүйн хэм хэмжээг хэвшүүлэх, төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн тухай гомдол, мэдээллийг ҮСХ-ны газар, нэгжид хандан Ёс зүйн хорооны гишүүдийн и-мэйл хаяг болон өөрийн биеэр хүлээн авахад боломжтой талаар мэдээлсэн.

Албан тушаалтанд давхар ажил эрхлэх тохиолдолын хүрээнд Үндэсний статистикийн хорооны тэргүүн дэд дарга Б.Бадамцэцэгийг Хөдөө аж ахуйн давхар даатгал ХК-ний Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр Сангийн сайдын тушаалаар томилсон.

Байгууллагын дарга, Ерөнхий менежерийн тушаалыг ил тод нээлттэй байдлаар байгууллагын nso.mn цахим хуудсанд тухай бүр байршуулж байна. /хувийг хавсаргав/

Түүнчлэн салбарын үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг нээлттэй байдлаар nso.mn цахим хуудсанд тухай бүр байршуулж байна. /хувийг хавсаргав/.

Өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлт, мэдээлэл хүлээн авах нөхцөлийг бүрдүүлж 1900-1212 утас, факс, цахим, бичгээр, амаар г.м хэлбэрээр хүлээн авч шийдвэрлэх шат дамжлагыг цөөрүүлэх, зөрчлийн талаарх мэдээллийг хүлээн авах үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байршуулсан.

Тайлант хугацаанд иргэдээс өргөдөл санал, мэдэгдэл, гомдол, хүсэлт болон Ашиг сонирхлын зөрчлийн талаарх мэдээлэл, мэдэгдэл ирүүлээгүй байна

Албан тушаалтан, албан хаагчдын шударга байдлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ шударга ёс, ёс зүй, сонирхлын зөрчлийн талаарх сургалт, хэлэлцүүлэг, ярилцлага, өдөрлөг, зөвлөмж өгөх ажлын хүрээнд

Албан хаагчийн шударга байдлыг нэмэгдүүлэх, шударга ёс, ёс зүй, сонирхлын зөрчлийн талаарх соён гэгээрүүлэх дараахь үйл ажиллагааг зохион байгуулж ярилцлага өдөрлөг зохион байгуулсан нь үр дүнтэй болсон Үүнд.

- УБИС –ийн Хууль, эрх зүйн тэнхмийн багш, илтгэгч н.Отгонбат-“Залуу хүний 7 дадал”

- Төр, нийгмийн нэрт зүтгэлтэн Ц.Лоохууз – “Амьдралын мөн чанар, шударга байхын ач холбогдол”
- Төрийн шагналт, ардын уран зохиолч Ш.Сүрэнжав – “Эрдэм номтой байхын давуу тал” сэдвээр тус тус ярилцлага амжилттай зохион байгуулагдлаа.

ТАЙЛАН БИЧСЭН: ЭБАТ

ТАНИЛЦСАН: БХЗГ-ЫН ДАРГА

Ш.ОЮУНГЭРЭЛ

Б.ГАНБАТ